

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Газар зүйн мэдээлэл.
Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт**

MNS 6925-4:2021

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Энэхүү стандартад Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт болон Олон улсын стандартын байгууллага (ISO)-ын 211-р стандартчиллын техникийн хороо (TC211-Geographic information/Geomatics)-ноос гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлага, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон хэсэгчлэн ашигласан.

Монгол Улсын Засгийн газраас үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, доктор Б.Сайнбуян, мэргэшсэн инженер Ц.Наранцацрал, А.Түрүүтүвшин, З.Нямбаяр, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, доктор, профессор Б.Чинбат, доктор, дэд профессор Г.Гантулга, Ж.Батсайхан, Ц.Ихбаяр, Б.Эрдэнэбаяр, П.Нямдаваа, М.Мягмаржаргал нар хамтран гүйцэтгэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүн, доктор С.Сайнбаяр редакц хийж, Монгол улсын их сургуулийн доктор, дэд профессор Ц.Базарханд шүүмжийг хийсэн.

Стандартын төсөлд холбогдох байгууллагуудаас санал, шүүмжийг авч тусгасан.

СХЗГ-ын ахлах мэргэжилтэн Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтолцооны 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандарттай нийцүүлэн хянасан.

Стандартын төслийг “Газрын салбарын стандартчиллын техникийн хороо” /ТХ-36/- ны 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.estandart.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

Агуулга

1	Хамрах хүрээ	1
2	Норматив эшлэл	1
3	Нэр томъёо, тодорхойлолт	2
3.1	Үндсэн агуулгад хамаарах ойлголт	2
3.2	Утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт	3
4	Техникийн шаардлага	4
4.1	Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага	4
4.2	Атрибурад тавих шаардлага	5
4.3	Кодын жагсаалтад тавих шаардлага	6
4.4	UML диаграммд тавих шаардлага	6
4.5	Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага	7
A	хавсралт (норматив) – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	8
B	хавсралт (норматив) – Кодын жагсаалт	22
C	хавсралт (норматив) – UML диаграмм	61
D	хавсралт (норматив) – Өгөгдлийн чанар	65
	Ном зүй	70

Оршил

Энэхүү стандарт нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандарт боловсруулах санаачилгыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачилсан бөгөөд энэхүү асуудлын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамтын оролцоотой бүтсэн баримт бичиг болно.

Стандартын төслийг нь холбогдох байгууллагууд буюу сонирхогч талуудаас өгсөн саналыг авч тусгасан бөгөөд хэрэглэх явцад гарсан дэвшилттэй болон дутагдалтай асуудлын хүрээнд стандартын үзлэгийг цаашид хийгдэх юм.

Стандартаар тогтоосон шаардлагыг хангасны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгох юм.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлсэн.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Энэхүү стандарт нь Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн агуулга нь газар ашиглалтын горим, газрын нөөц, түүнийг зохистой хэрэглэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан суурь зурган мэдээллээр хангах, бүх шатны тайлан, мэдээ гаргах мөн нийгэм, эдийн засгийн бодлого, менежментийг сайжруулах замаар боловсруулалт хийн ашиглах боломж бүхий мэдээллийг агуулахад оршино.

ТМОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-4 : 2021
Geographic information. Data Specification on Land Use	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн С/36 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандартыг Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн сан нь газрын нэгдмэл сан, газар зохион байгуулалтын төлөвлөлт, баримт бичиг, хамгаалалтын бүс тэдгээртэй холбоотой мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү стандарт нь газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Огноо заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Огноо заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO 19125-1: 2004, Газар зүйн мэдээлэл – Энгийн биетийн хандалт - 1-р хэсэг: Нийтлэг архитектур;

ISO 19135: 2007, Газар зүйн мэдээлэл – Бүртгэлийн процедур;

MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, хөрс, агаар, сансрын, газрын хэвлийн орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц.

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл.

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрөл

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрөл.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрсэлсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

мета өгөгдөл

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

3.1.8

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадаа ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.9**домэйн**

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болно.

3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт**3.2.1****Boolean**

тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005-аас үзэж болно).

3.2.3**Character string**

тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005-аас үзэж болно).

3.2.4**Date time**

цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005-аас үзэж болно).

3.2.5**Identifier**

өгөгдөл мэдээллийг хариуцагч эрх бүхий байгууллагаас олгосон орон зайн объектын танигч буюу тодорхойлогч. Энэ нь тухайн өгөгдлийг бусад программ, системүүд лавлах, холбох үед ашиглана. (Дэлгэрэнгүй мэдээллийг INSPIRE DS-D2.5-аас үзэж болно).

3.2.6**GM_Object**

геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд Газар зүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO 19107:2003-аас үзэж болно).

3.2.7**GM_MultiSurface**

олон гадаргуу бүхий геометр биет. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO 19107:2003-аас үзэж болно).

3.2.8**GM_Curve**

тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO 19107:2003-аас үзэж болно).

3.2.9


Measure

хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. (Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005-аас үзэж болно).

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй байна. (1-р зургаас үзнэ үү)



1-р зураг – Газар ашиглалтын өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 Орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн А хавсралт норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр тус тусад нь нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хавсралтын хүснэгтийн дагуу **Одоо байгаа газар ашиглалт, газар ашиглалтын растер хэлбэр, газар зохион байгуулалтын төлөвлөгөө** гэсэн 3 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн санд 6 биет төрөл, 2 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибурад тавих шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /ExternalID/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /localID/, “нэрийн талбар” /namespace/, “танигчийн хувилбар” /versionID/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ.

4.2.3.1 “Дотоод танигч /Local ID/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version ID/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

4.2.4 Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1-4.2.4.2–д заасан “Газар зүйн нэр” /Geographical Name/, “Орто-зураглал” /Orthoimagery/ дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Орто-зураглал” /Coverage function/ нь Давхаргын функц /Coverage function/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Давхаргын функц» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “MNS 6925-11 : 2021, Газар зүйн мэдээлэл. Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт” стандартаас авч ашиглана.

4.2.4.2 “Газар зүйн нэр” /Geographical Name/ нь тухайн газар усны нэр “Нэр” /name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газар зүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “MNS 6925-3 : 2021, Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Газар ашиглалт орон зайн өгөгдлийн санд 14 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу В хавсралтаас ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив)

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language) диаграммын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь газар ашиглалтын суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.6-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

ТАЙЛБАР: Эдгээр шаардлага нь олон улсын ISO 19157 стандартад заасан чанарын үзүүлэлтүүд юм. Энэхүү дурдсан ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөх нь олон улсын хэмжээний нэгдсэн үзүүлэлттэй байх зарчимд нийцдэг.

4.5.2 Газар ашиглалтын суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 “Бүрэн бүтэн байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объектын төрлийн түвшнээс илүү гарах эсвэл дутахгүй байх шаардлагатай.

4.5.2.2 “Утга агуулгын нийцтэй байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд ойлголт, домэйн, формат, топологийн алдаагүй, утга агуулгын хувьд нийцтэй байна.

4.5.2.3 “Байрлалын нарийвчлал”-ыг хангах шаардлага болох орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин байна.

4.5.2.4 “Сэдэвчилсэн нарийвчлал”-ын өгөгдлийн багц, биет төрөл, өгөгдөл төрөл, эдгээрийн атрибут нь үнэн зөв бөгөөд сэдэв агуулгын дагуу байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Газар ашиглалтын орон зайн суурь өгөгдлийн багц ба ангилал

А.1.1 Өгөгдлийн багц: Газар ашиглалтын одоогийн байдал (Existing land use)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Газар ашиглалтын объект <i>/Existing land use object/ d</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Газар ашиглалтын объект нь газар ашиглалтын хэлбэрүүдийг тодорхойлдог.
2	Газрын нэгдмэл сан <i>/Unified land territory/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Газрын нэгдмэл сангийн үндсэн, дэд дэлгэрэнгүй ангиллын газрын байршил, хил заагт хамаарах, тоо, хэмжээг тодорхойлох цогц үйл ажиллагаа хамаарна.
3	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 1 <i>/Classification level value1/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг авна. Classification level value1-ийн ангиллын утгуудаас авна.
4	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 2 <i>/Classification level value2/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын нэгдмэл сангийн дэд ангиллыг /зориулалтаар/ авна. Classification level value2-ийн ангиллын утгуудаас авна.
5	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 3 <i>/Classification level value3/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын нэгдмэл сангийн ангиллын дэлгэрэнгүй ангилал/газар ашиглалтын зориулалтыг авна. Classification level value3-ийн ангиллын утгуудаас авна.
6	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 4 <i>/Classification level value4/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын нэгдмэл сангийн ангиллын дэлгэрэнгүй ангилал /газар ашиглалтын зориулалтын “Хот тосгон, бусад суурин газрын газар ашиглалтын зориулалт”-ын ангиллын үйл ажиллагааны чиглэлийн ангиллыг авна. Classification level value4 -ийн ангиллын утгуудаас авна.

А.1.2 Өгөгдлийн багц: Газар ашиглалтын растер хэлбэр (Gridded land use)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
-----	---------------	--------------	---------------	--------------

1	Газар ашиглалтын растер хэлбэр <i>/Existing land use grid/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Грид	Газар ашиглалтын (одоо эсвэл өнгөрсөн) мэдээлэл бүхий талбайн пикселийн олонлог. Газар ашиглалт <i>/Existing land use/-</i> ыг растер хэлбэрээр дүрсэлсэн өгөгдөл..
---	---	---------------------------------------	------	---

А.1.3 Өгөгдлийн багц: Газар зохион байгуулалтын төлөвлөгөө (Planned land use)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Газар зохион байгуулалтын төлөвлөлт <i>/Land use plan/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Полигон	Тухайн газрын нийгэм эдийн засаг байгалийн онцлог, шинж чанарт тулгуурлан газрыг зүй зохистой, оновчтой, бүрэн дүүрэн ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тооцсон ямар зориулалтаар хэчнээн хэмжээний газрыг хаана, хэрхэн эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах нөөц боломжийг тодорхойлсон бодлогын бичиг баримт.
2	Төлөвлөлтийн ерөнхий бүсийн ангилал <i>/Land use plan zone class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газар ашиглалтын өөр өөр чиг үүрэг, шаардлага бүхий 1 буюу түүнээс дээш дэд бүсүүдийг дотроо агуулсан бүс газрыг Land use plan zone class value -ийн ангиллын утгуудаас авна.
3	Төлөвлөлтийн дэд бүсийн ангилал <i>/Land use plan subzone class value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бүсийн хил зааг доторх газар ашиглалтын тодорхой чиг үүрэг, шаардлага бүхий төлөвлөлтийн ерөнхий бүсэд хамаарах нэгж дэд бүсийг Land use plan subzone class value -ийн ангиллын утгуудаас авна.
4	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний түвшний ангилал <i>/Level of spatial plan value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Улс, нийслэл, аймаг, дүүрэг, сумын тухайн шатны газрыг зүй зохистой, оновчтой, бүрэн дүүрэн ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тооцсон, дүгнэсэн, зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичиг юм. Газрын багц хуулиар газар зохион байгуулалтын төлөвлөгөөний шинэ түвшин нэмэгдсэн тохиолдолд хуульд нийцүүлнэ.
5	Газар зохион байгуулалтын арга хэмжээний төрөл <i>/Land management and administration actions value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, газар зохион байгуулалт хийх арга хэмжээ. Land management and administration actions value-ийн ангиллын утгуудаас авна.
6	Газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний төрөл	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ. Land restoration and rehabilitation actions value-ийн ангиллын утгуудаас авна.

	<i>/Land restoration and rehabilitation actions value/</i>			
7	Тогтоол, шийдвэр <i>/Ordinance value/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Засаг захиргааны тогтоолын талаарх лавлагаа. Хамтран хэлэлцэж батлах үндсэн дээр гаргасан, удирдлагын үйл ажиллагаанд үүсэж хөтлөгддөг захирамжийн баримт бичиг юм.
8	Төлөвлөгөөний төслийн үе шатны ангилал <i>/Planning phase value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үе шат, явцын төлөв. Planning phase value- ийн ангиллын утгуудаас авна.
9	Нэмэлт зохицуулалт <i>/Supplementary regulation/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг, Шулуун, полигон	Орон зайн төлөвлөлтийн үндэслэл эсвэл хууль эрх зүйн бичвэрт тодорхойлсон дүрмийг боловсруулахад шаардлагатай нэмэлт мэдээлэл болон газар ашиглалтыг төлөвлөхөд хязгаарлалтыг агуулсан орон зайн төлөвлөлтийн төрлүүд (цэг, шугам эсвэл олон өнцөгт).
10	Нэмэлт зохицуулалтын ангилал 1 <i>/Supplementary regulation value1/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Өгөгдөл бүрдүүлэгчээс гаргах боломжтой нэмэлт зохицуулалтын ангилал. Хориглох, хязгаарлах газар ашиглалтын төрлүүд. Supplementary regulation value1-ийн ангиллын утгуудаас авна.
11	Нэмэлт зохицуулалтын ангилал 2 <i>/Supplementary regulation value2/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Өгөгдөл бүрдүүлэгчээс гаргах боломжтой нэмэлт зохицуулалтын дэд ангилал. Газар зохион байгуулалтын нэмэлт зохицуулалт. Жишээ: Барилгын өндрийн зохицуулалт гэх мэт. Supplementary regulation value2-ийн ангиллын утгуудаас авна.
12	Нэмэлт зохицуулалтын ангилал 3 <i>/Supplementary regulation value3/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Орон зайн төлөвлөлтийн хязгаарлалт болон нөхцөлийн дэлгэрэнгүй төрөл. Газар зохион байгуулалтын нэмэлт зохицуулалт. Жишээ: Барилгын бүрхцийн харьцаа гэх мэт. Supplementary regulation value3-ийн ангиллын утгуудаас авна.
13	Нэмэлт зохицуулалтын ангилал 4 <i>/Supplementary regulation value4/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Орон зайн төлөвлөлтийн хязгаарлалт болон нөхцөлийн нарийвчилсан төрөл. Газар зохион байгуулалтын нэмэлт зохицуулалтын Specific supplementary regulation value4-ийн ангиллын утгуудаас авна.

14	Газар ашиглалтын төлөвлөлтийн бүс /Land use plan zone/	«биет төрөл» /feature type/	Полигон	Тухайн бүсийн хил зааг дотор явуулах үйл ажиллагааны чиглэл, бодлого бүхий, газар ашиглалтын шаардлага, чиг үүргийг тодорхойлсон бүс газар.
15	Төлөвлөлтийн арга хэмжээ /Land management actions/	«биет төрөл» /feature type/	Полигон	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц – Газар ашиглалтын одоогийн байдал (Existing land use)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Газар ашиглалтын объект (Existing land use object)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу GM_MultiSurface	-	-	Орон зайн объектын геометрийн дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.
6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж эхэлсэн хугацаа.

8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж дууссан хугацаа.
9	Талбай /Area/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	20	Газар ашиглалтын нэгжийн талбайн хэмжээ.
10	Хувь /Percentage/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Энэ тодорхой хэсгийг бүрхэх газар ашиглалтын объектын эзлэх хувь.
11	Газрын нэгдмэл сан /Unified land territory/	«Газрын нэгдмэл сан» «Unified land territory»	-	-	Газрын нэгдмэл сангийн үндсэн, дэд, дэлгэрэнгүй ангиллын газрын байршил, хил зааг, түүнд хамаарах тоо, хэмжээг тодорхойлох цогц үйл ажиллагаа хамаарна.
12	Ажиглалт, судалгааны огноо /Observation date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Зураглалтай холбоотой ажиглалт, судалгааны огноо. Энэ нь агаарын болон хиймэл дагуулын зураглалын эсвэл хээрийн судалгааны огноо байж болно. Мэдээллийн сангийн бүх объект нь ижил цаг хугацаанд бүрдүүлэгдсэн байх боломжгүй байдаг.
13	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /Administrative unit/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. Administrative unit sub class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.

A.2.1.2 Өгөгдөл төрлийн нэр: Газрын нэгдмэл сан (Unified land territory)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Газрын нэгдмэл сангийн ангиллын утга 1 /Unified land territory type1/	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 1 /Classification level value1/	-	-	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг авна. Classification level value1-ийн ангиллын утгуудаас авна.
2	Газрын нэгдмэл сангийн ангиллын утга 2 /Unified land territory type2/	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 2 /Classification level value2/	-	-	Газрын нэгдмэл сангийн дэд ангиллыг /зориулалтаар/ авна. Classification level value2-ийн ангиллын утгуудаас авна.
3	Газрын нэгдмэл сангийн ангиллын утга 3 /Unified land territory type3/	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 3 /Classification level value3/	-	-	Газрын нэгдмэл сангийн ангиллын дэлгэрэнгүй ангилал/газар ашиглалтын зориулалтыг авна. Classification level value3-ийн ангиллын утгуудаас авна.
4	Газрын нэгдмэл сангийн ангиллын утга 4 /Unified land territory type4/	Газрын нэгдмэл сангийн ангиллын түвшин 4 /Classification level value4/	-	-	Газрын нэгдмэл сангийн ангиллын дэлгэрэнгүй ангилал /газар ашиглалтын зориулалтын “Хот тосгон, бусад суурин газрын газар ашиглалтын зориулалт”-ын ангиллын үйл ажиллагааны чиглэлийн ангиллыг авна. Classification level value4-ийн

					ангиллын утгуудаас авна.
--	--	--	--	--	--------------------------

A.2.2 Өгөгдлийн багц - Газар ашиглалтын растер хэлбэр (Gridded land use)

A.2.2.1 Биет төрлийн нэр: Газар ашиглалтын растер хэлбэр (Existing land use grid)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Орон зайн объектын геометрийн дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.
6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж эхэлсэн хугацаа.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж дууссан хугацаа.
9	Нэр /Name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Газар ашиглалтын нэр.
10	Өргөтгөл /Extent/	Оронзайн хамрах хүрээ /EX_Extent/	-	-	Өгөгдлийн багц хэмжээг агуулна. Газар ашиглалтын орон зай, цаг хугацаа эсвэл орон зайд тодорхойлж болно.

					Багц өгөгдлийн өргөтгөлийг агуулна.
11	Давхаргын функц /Coverage function/	«Давхаргын функц» «Coverage function»	-	-	Домэйний давхаргын байршил дахь цар хүрээний утгыг хэрхэн хүлээн авах тухай тайлбар.
12	Домэйний багц /Domain set/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Координатын нэр томъёог тайлбарласан давхаргын домэйний хэлбэр.
13	Утгын багц /Range Set/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Давхаргын домэйний элементүүдтэй давхаргын үүргээр холбогдсон биет атрибутын утгын багц.
14	Мета-өгөгдөл /Meta data/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Давхаргын нарийвчилсан мета өгөгдлийн хэрэглээ.
15	Цар хүрээний төрөл /Range type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Утгын цар хүрээний бүтцийн тайлбар.

А.2.3 Өгөгдлийн багц - Газар зохион байгуулалтын төлөвлөгөө (Planned land use)

А.2.3.1 Биет төрлийн нэр: Газар зохион байгуулалтын төлөвлөлт (Land use plan)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Газар зохион байгуулалтын төлөвлөлт /Land use plan/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Орон зайн объектын геометрийн дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.

6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
7	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний түвшин /Level of spatial plan/	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний түвшний ангилал /Level of spatial plan value/	-	-	Газрын тухай хууль, хот байгуулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичгийн төрөл. Level of spatial plan value-ийн ангиллын утгуудаас авна.
8	Газар зохион байгуулалтын арга хэмжээ /Planned land management actions/	Газар зохион байгуулалтын арга хэмжээний төрөл /Planned land management actions value/	-	-	Газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, газар зохион байгуулалт хийх арга хэмжээ. Planned land management actions value-ийн ангиллын утгуудаас авна.
9	Газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ /Restoration and rehabilitation actions/	Газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний ангилал /Restoration and rehabilitation actions value/	-	-	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ. Restoration and rehabilitation actions value -ийн ангиллын утгуудаас авна.
10	Газрын эрх олгох арга хэмжээ /Planned land titling actions/	Газрын эрх олгох арга хэмжээний ангилал /Planned land titling actions value/	-	-	Газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх арга хэмжээ. Planned land titling actions value -ийн ангиллын утгуудаас авна.
11	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /Administrative unit/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. Administrative unit sub class value - кодын жаргаалтын утгаас авч ашиглана.
12	Тогтоол /Ordinance/	«Тогтоол, шийдвэр» «Ordinance value»	-	-	Холбогдох тогтоолын талаарх лавлагаа. Ordinance value өгөгдөл төрлөөс авна.
13	Төлөвлөгөөний төслийн үе шат /Planning phase/	Төлөвлөгөөний төслийн үе шатны ангилал /Planning phase value/	-	-	Төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үе шат, явцын төлөв. Planning phase value- ийн ангиллын утгуудаас авна.

A.2.3.2 Өгөгдөл төрлийн нэр: Тогтоол, шийдвэр (Ordinance value)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Тогтоолын баримт бичгийн огноо /Ordinance date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Тогтоолын баримт бичигтэй холбоотой огноо.
2	Төлөвлөлтийн баримт бичгийн нэр /Ordinance name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Төлөвлөлтийн тогтоолын баримт бичгийн нэр.
3	Тогтоолын баримт бичгийн үндэслэл /Ordinance reference/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Тогтоолын баримт бичгийн үндэслэл. Түүнтэй холбоотой лавлагаа.

А.2.3.3 Биет төрлийн нэр: Нэмэлт зохицуулалт (Supplementary regulation)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн геометрийн дүрслэл.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.
6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж эхэлсэн хугацаа.

8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулж ашиглаж дууссан хугацаа.
9	Нэмэлт зохицуулалт 1 /Supplementary regulation1/	Нэмэлт зохицуулалтын ангилал 1 /Supplementary regulation value1/	-	-	Хориглох, хязгаарлах газар ашиглалтын төрлүүд. Supplementary regulation value1-ийн ангиллын утгуудаас авна.
10	Нэмэлт зохицуулалт 2 /Supplementary regulation2/	Нэмэлт зохицуулалтын ангилал 2 /Supplementary regulation value2/	-	-	Бүсийн нэмэлт зохицуулалтын дэд ангиллууд. Жишээ: Барилгын өндрийн зохицуулалт гэх мэт. Supplementary regulation value2-ийн ангиллын утгуудаас авна.
11	Нэмэлт зохицуулалт 3 /Supplementary regulation3/	Нэмэлт зохицуулалтын ангилал 3 /Supplementary regulation value3/	-	-	Бүсийн нэмэлт зохицуулалт. Supplementary regulation value3-ийн ангиллын утгуудаас авна.
12	Нэмэлт зохицуулалт 4 /Supplementary regulation4/	Нэмэлт зохицуулалтын ангилал 4 /Supplementary regulation value4/	-	-	Бүсийн нэмэлт зохицуулалтын дэлгэрэнгүй ангилал. Supplementary regulation value4-ийн ангиллын утгуудаас авна.
13	Бусад төлөвлөгөөнөөс авсан /Inherited from other plans/	Логик /Boolean/	Логик /Boolean/	5	Нэмэлт зохицуулалтыг бусад төлөвлөгөөнөөс шилжүүлж авсан төлөвлөлтийг заана.

А.2.3.4 Биет төрлийн нэр: Газар ашиглалтын төлөвлөлтийн бүс (Land use plan zone)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Бүсийн элементийн геометр.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний

					хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.
6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
8	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулан ашиглаж эхэлсэн хугацаа.
9	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулан ашиглаж дууссан хугацаа.
10	Төлөвлөлтийн ерөнхий бүс /Land use plan zone class/	Төлөвлөлтийн ерөнхий бүсийн ангилал /Land use plan zone class value/	-	-	Газар ашиглалтын өөр өөр чиг үүрэг, шаардлага бүхий 1 буюу түүнээс дээш дэд бүсүүдийг дотроо агуулсан бүс газар. Land use plan zone class value -ийн ангиллын утгуудаас авна.
11	Төлөвлөлтийн дэд бүс /Land use plan subzone/	Төлөвлөлтийн дэд бүсийн ангилал /Land use plan subzone class value/	-	-	Бүсийн хил зааг доторх газар ашиглалтын тодорхой чиг үүрэг, шаардлага бүхий төлөвлөлтийн ерөнхий бүсэд хамаарах нэгж дэд бүсийг Land use plan subzone class value -ийн ангиллын утгуудаас авна.
12	Газрын нэгдмэл сан /Unified land territory/	«Газрын нэгдмэл сан» «Unified land territory»	-	-	Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал /газар ашиглалтын зориулалт/ хамаарна. Төлөвлөлтөд хамаарах газрын харгалзах нэгдмэл сангийн утгыг тавина. Unified land territory-ийн ангиллын утгуудаас авна.
13	Газар зохион байгуулалтын арга хэмжээ /Land management and administration actions/	Газар зохион байгуулалтын арга хэмжээний төрөл /Land management and administration actions value/	-	-	Газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, газар зохион байгуулалт хийх арга хэмжээ. Land management and administration actions Value-ийн ангиллын утгуудаас авна.
14	Газрыг нөхөн сэргээх, хамгаалах	Газрыг нөхөн сэргээх,	-	-	Газрыг хамгаалах, нөхөн сэргээх,

	арга хэмжээ /Restoration and rehabilitation actions/	хамгаалах арга хэмжээний ангилал /Restoration and rehabilitation actions value/			газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ. Restoration and rehabilitation actions value-ийн ангиллын утгуудаас авна.
15	Газрын эрх олгох арга хэмжээ /Planned land titling actions/	Газрын эрх олгох арга хэмжээний ангилал /Planned land titling actions value/	-	-	Газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх арга хэмжээ.
16	Бүсийн зохицуулалт, шаардлага 1 /Zoning regulation and rules 1/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Хориглох, хязгаарлах газар ашиглалтын төрлүүд.
17	Бүсийн зохицуулалт, шаардлага 2 /Zoning regulation and rules 2/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Бүсийн нэмэлт зохицуулалт. Жишээ: Барилгын өндрийн зохицуулалт гэх мэт.
18	Бүсийн зохицуулалт, шаардлага 3 /Zoning regulation and rules 3/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Бүсийн нэмэлт зохицуулалт.
19	Төлөвлөгөөний төслийн үе шат /Planning phase/	Төлөвлөгөөний төслийн үе шатны ангилал /Planning phase value/	-	-	Төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үе шат, явцын төлөв. Planning phase value -ийн ангиллын утгуудаас авна.

A.2.3.5 Биет төрлийн нэр: Төлөвлөлтийн арга хэмжээ (Land management actions)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Геометр хэмжээсийг оруулна.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

5	Мэдээлэл бүртгэсэн хугацаа /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн хувилбарын огноо, цаг.
6	Мэдээлэл шинэчилсэн, дуусгавар болсон хугацаа /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг орон зайн өгөгдлийн санд нөхөн оруулсан эсвэл дуусгавар болсон хувилбарын огноо, цаг.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулан ашиглаж эхэлсэн хугацаа.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Газар ашиглалтын өгөгдөл оруулан ашиглаж дууссан хугацаа.
9	Нэгж талбарын дугаар /Parcel ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар.
10	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /Administrative unit sub class/	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд ангилал /Administrative unit sub class value/	-	-	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн сум, дүүргийн ангилал. Administrative unit sub class value - кодын жагсаалтын утгаас авч ашиглана.
11	Газрын нэр /Geographical name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Газрын нэр, албан ёсны хаяг байршлыг тавина. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлтийн стандартаас авна.
12	Төлөвлөлтийн ерөнхий бүс /Land use plan zone class/	Төлөвлөлтийн ерөнхий бүсийн ангилал /Land use plan zone class value/	-	-	Газар ашиглалтын өөр өөр чиг үүрэг, шаардлага бүхий 1 буюу түүнээс дээш дэд бүсүүдийг дотроо агуулсан бүс газрыг Land use plan zone class value -ийн ангиллын утгуудаас авна.
